

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДЭД ХУВИЙН ДУГААР ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд буюу “барьцаалан зээлдүүлэх газар”, байнга ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн буюу “зээлийн үйлчилгээ” эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувийн дугаар нь бүртгэх байгууллагад бүртгэгдсэн Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг тодорхойлсон 10 оронтой тоогоор илэрхийлсэн код байх ба хувийн дугаарын эхний орон нь бүртгэх байгууллагыг, хоёр дахь орон нь хувь хүн, хуулийн этгээдийн аль нь болохыг, дараагийн 2 орон нь бүртгэсэн байгууллагын байршлыг, дараагийн 2 орон нь бүртгэл олгосон оны сүүлийн 2 оронг, дараагийн 4 орон нь бүртгэсэн эрх бүхий байгууллагын бүртгэлийн дугаарыг илэрхийлнэ.
- 1.3. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд Санхүүгийн зохицуулах хороо болон аймаг, нийслэлийн Засаг даргаас олгосон хүчин төгөлдөр нэг хувийн дугаартай байх ба барьцаалан зээлдүүлэх газрын салбарын хувийн дугаарыг үндсэн хувийн дугаараас хойш 3 оронгоор илэрхийлнэ.

ХОЁР. ХУВИЙН ДУГААР ОЛГОХ

- 2.1. Хувийн дугаарыг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсэгт заасны дагуу холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн бүртгэх байгууллага дугаар олгож, бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэгээ хийнэ.
- 2.2. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хаяг байршил өөрчлөгдсөн тохиолдолд бүртгэлийн дугаарт өөрчлөлт оруулахгүй.
- 2.3. Хувийн дугаарын сүүлийн 4 орныг олгохдоо шинэ он эхлэх бүр эхнээс нь дугаарлах бөгөөд хуулийн этгээд буюу “барьцаалан зээлдүүлэх газар”, хувь хүн буюу “зээлийн үйлчилгээ” эрхлэх этгээдийг харгалзахгүй дараалуулан дугаарлана.
- 2.4. Хүчингүй болсон хувийн дугаарыг дахин олгохгүй.

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд
хувийн дугаар олгох журмын хавсралт 1

№	ДЭЛГЭРЭНГҮЙ	ТОВЧЛОЛ
1	Санхүүгийн зохицуулах хороо	1
	Аймгийн засаг дарга	2
2	Хувь хүн	1
	Хуулийн этгээд	2
3	Улаанбаатар хот	01
	Архангай	02
	Баян-Өлгий	03
	Баянхонгор	04
	Булган	05
	Говь-Алтай	06
	Говьсүмбэр	07
	Дархан-Уул	08
	Дорноговь	09
	Дорнод	10
	Дундговь	11
	Завхан	12
	Орхон	13
	Өвөрхангай	14
	Өмнөговь	15
	Сүхбаатар	16
	Сэлэнгэ	17
	Төв	18
	Увс	19
	Ховд	20
Хөвсгөл	21	
Хэнтий	22	

Жишээ нь: 1201220001 гэвэл Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаалаар Барьцаалан зээлдүүлэх газрын бүртгэлийн зөвшөөрлийг Улаанбаатар хотод 2022 онд олгож 1 дугаарт бүртгэсэн гэсэн утгыг илэрхийлнэ. Хувийн дугаарт мөнгөн зээлийн үйлчилгээ үзүүлэгчийн хаяг байршил хамааралгүй болно.

Салбарын хувьд: 1201220001-001 гэж дугаарлана.